

**ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр

Дугаар 26/14

Улаанбаатар хот

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 59.1, 60.1, 61.1.2, 61.4 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн “Инновэйшн инвестмент” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай асуудлаар хэлэлцэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдөр 15:00 цагт /<https://agm.mn/> холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
  1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгож, шинээр томилох тухай.
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөр тогтоосугай.
4. Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдэд саналаа урьдчилан өгөх боломжоор хангаж /<https://agm.mn/> холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр болон Хувьцаа эзэмшигч өөрийн харилцдаг брокер дилерийн компаниар дамжуулан Компанийн өөрийн байранд буюу Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандигийн гудамж, НМ төв, 8 давхар хаягт урьдчилсан саналын хуудсыг хүлээн авах ба санал авах сүүлийн хугацаа нь 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 15:00 цаг байна.
5. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг 1 дүгээр хавсралтаар, хурлын дэгийг 2 дугаар хавсралтаар, хурлаар танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг 3 дугаар хавсралтаар, хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар кумулятив аргаар санал авах саналын хуудасны загварыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг удирдах хурлын дарга А.Баттамир, тооллогын комиссын даргаар “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Харилцагчийн албаны захирал Б.Онон, тооллогын комиссын гишүүнээр “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Харилцагчийн албаны мэргэжилтэн М.Оюунсүвд нарыг тус тус томилсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зохион байгуулах комиссын даргаар Б.Энхболд, гишүүнээр О.Маралмаа, хурлыг зохион байгуулах комиссын нарийн бичгийн даргаар П.Мөнхтуяа нарыг тус тус томилсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлах тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-д тус тус хүргүүлэх болон 1 дүгээр хавсралтаар баталсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг 2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн дотор Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон

өдөр тутмын сонин, олон нийтийн телевизийн мэдээгээр хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа дахин мэдээлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Энхболд)-д даалгасугай.

9. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн танилцах 3 дугаар хавсралтад заасан бичиг баримтыг 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн үнэт цаасны компаниуд, мөн компанийн албан ёсны цахим хуудсаар болон хурал зохион байгуулах комисс, ТУЗ-ийн нарийн бичгийн даргаас авч танилцах эрхтэй бөгөөд түүнтэй танилцах боломжийг хувьцаа эзэмшигчдэд олгох нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Энхболд)-д даалгасугай.
10. Хурлын бэлтгэл ажлыг хангах, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах, энэ тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад журамд заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо, "Монголын хөрөнгийн бирж" ХК-д хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (О.Маралмаа)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.БАТТАМИР

“Инновэйшн Инвестмент” ХК-ийн Төлөөлөн  
удирдах зөвлөлийн хурлын 2026 оны 04 дүгээр  
сарын 08-ны өдрийн 26/14 тоот тогтоолын 1  
дүгээр хавсралтаар батлав.



## **“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

“Инновэйшн инвестмент” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдөр 15:00 цагт /<https://agm.mn/> холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр зохион байгуулагдана.

Цахим хурал зохион байгуулах холбоос: <https://agm.mn/>

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр:  
2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

### **Хурлаар хэлэлцэх асуудлууд:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгож, шинээр томилох тухай.

Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчид урьдчилж саналаа өгөхдөө /<https://agm.mn/> холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр болон өөрийн харилцдаг брокер дилерийн компаниар дамжуулан эсхүл Компанийн өөрийн байранд буюу Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандигийн гудамж, НМ төв, 8 давхар хаягт биеэр ирж цаасаар өгөх боломжтой. Урьдчилан санал авах сүүлчийн хугацааг 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 15:00 цагаар тасалбар болгоно.

Аж ахуй нэгжийг төлөөлөн итгэмжлэлээр хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл хурал зохион байгуулах комисстой урьдчилан холбогдон тодруулага, мэдээлэл авна уу.


Хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг хурал зохион байгуулах комиссын утсаар холбогдон авна уу.

Холбоо барих: 75551919, 99907664, 88004829

Мэйл хаяг: [boardsecretary@qpay.mn](mailto:boardsecretary@qpay.mn)

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**


“Инновэйшн Инвестмент” ХК-ийн Төлөөлөн  
удирдах зөвлөлийн хурлын 2026 оны 04 дүгээр  
сарын 08-ны өдрийн 26/14 тоот тогтоолын 2  
дугаар хавсралтаар батлав.



**“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС  
ХУРЛЫН ДЭГ**

| Хугацаа     | Хөтөлбөр                                                                                                                                                                                                                                                                                                                     | Хариуцах                                                  |
|-------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------|
| 15:00-15:10 | Хурлын ирцийг бүртгэх                                                                                                                                                                                                                                                                                                        | Тооллогын комисс                                          |
| 15:10-15:15 | Хурлын ирцийг мэдээлэх                                                                                                                                                                                                                                                                                                       | Тооллогын комисс                                          |
| 15:15-15:20 | Хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах                                                                                                                                                                                                                                                      | Хурлын дарга                                              |
| 15:20-16:00 | Хурлаар танилцах асуудлуудыг танилцуулах:<br>• Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга<br><br>Хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулах:<br>• Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгож, шинээр томилох тухай. | Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо<br><br>Хурлын дарга |
| 16:00-16:20 | Асуулт, хариулт, санал                                                                                                                                                                                                                                                                                                       |                                                           |
| 16:20-16:40 | Санал хураалт                                                                                                                                                                                                                                                                                                                |                                                           |
| 16:40-16:50 | Хурлын завсарлага                                                                                                                                                                                                                                                                                                            |                                                           |
| 16:50-17:00 | Санал хураалтын нэгдсэн дүнг гаргаж, дүнг танилцуулах                                                                                                                                                                                                                                                                        | Тооллогын комисс                                          |
| 17:00-17:10 | Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах                                                                                                                                                                                                                                                                                 | Хурлын дарга                                              |
| 17:10-17:15 | Хурлыг хаах                                                                                                                                                                                                                                                                                                                  | Хурлын дарга                                              |


“Инновэйшн Инвестмент” ХК-ийн Төлөөлөн  
удирдах зөвлөлийн хурлын 2026 оны 04 дүгээр  
сарын 08-ны өдрийн 26/14 тоот тогтоолын 3  
дугаар хавсралтаар батлав



**“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС  
ХУРЛЫН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоол, шийдвэрийн төсөл.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын санал авах хуудас.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралтай холбогдох бусад баримт бичиг

“Инновэйшн Инвестмент” ХК-ийн Төлөөлөн  
удирдах зөвлөлийн хурлын 2026 оны 04 дүгээр  
сарын 08-ны өдрийн 26/14 тоот тогтоолын 4  
дүгээр хавсралтаар батлав.



## “ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог: ..... нэр .....  
Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар: .....  
Регистрийн дугаар/ Иргэнийн бүртгэлийн дугаар: .....  
Санал өгөх хувьцааны тоо: .....

Бүртгэсэн /Үнэт цаасны компани / .....  
Брокерийн овог ..... нэр .....

“Инновэйшн инвестмент” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 15:00, /<https://agm.mn/> холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр хуралдана.

### Санал хураах арга: Кумулятив

Санал хураах кумулятив аргыг хэрэглэх тухай тайлбар:

- Кумулятив аргыг хэрэглэхэд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй энгийн нэг хувьцаа нь компанийн дүрмээр тогтоосон ТУЗ-ийн нийт гишүүдийн тоотой тэнцүү саналын эрхтэй байна.
- Хувьцаа эзэмшигч нь саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.

**Жишээ нь:** Хувьцаа эзэмшигч А нь 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Компанийн дүрмээр тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон. Хувьцаа эзэмшигч А-ийн эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй /100\*9 гишүүн 900/ болно.

**Хувилбар А:** Хувьцаа эзэмшигч нь нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.

**Хувилбар Б:** Хувьцаа эзэмшигч нь нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч нь саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.

### 1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчийг сонгох

Саналын эрхтэй хувьцааны тоо- .....

| № | Нэр дэвшигчийн овог, нэр | Саналын тоо |
|---|--------------------------|-------------|
| 1 |                          |             |
| 2 |                          |             |
| 3 |                          |             |
| 4 |                          |             |
| 5 |                          |             |
| 6 |                          |             |

### 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчийг сонгох

Саналын эрхтэй хувьцааны тоо- .....

| № | Нэр дэвшигчийн овог, нэр | Саналын тоо |
|---|--------------------------|-------------|
| 1 |                          |             |
| 2 |                          |             |
| 3 |                          |             |

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, гарын үсгийн тайлал: ..... /  
/ гарын үсэг /

Саналын хуудсыг бүртгэж, хүлээж авсан ажилтны гарын үсэг, гарын үсгийн тайлал: ..... /  
/ гарын үсэг, тэмдэг /

Энэ хэсгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудсыг хүчинтэйд тооцов: ...../

/

Саналын хуудас хүчингүйд тооцсон бол шалтгаан:.....

2026 оны ..... сар ..... өдөр


**САНАЛЫН ХУУДСЫГ БӨГЛӨХ САНАМЖ:**

Саналын хуудсыг дараах зааврын дагуу бөглөнө

1. Саналыг ердийн аргаар тоолох асуудалд:

- Тухайн асуудалд зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн гэсэн аль нэгд нь ✓ эсвэл + тэмдгээр санал өгнө.
- Саналаа урьдчилсан байдлаар /<https://agm.mn/> холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр болон цаасан хэлбэрээр өгөх бол өөрийн үйлчлүүлдэг брокер дилерийн компаниар дамжуулан эсвэл компанийн байранд биеэр ирж цаасаар өгөх боломжтой. Урьдчилан санал авах сүүлчийн хугацааг 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 15:00 цагаар тасалбар болгоно.
- Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн саналаа өгөх тохиолдолд таныг төлөөлөх хүндээ Монгол улсын хууль тогтоомжид нийцсэн итгэмжлэл үйлдэн нотариатаар гэрчлүүлэх бөгөөд Таны санал итгэмжлэлийн хамт хүчинтэйд тооцно.
- Засварласан, балласан, эсвэл болон аль нэг саналыг бөглөөгүй бол саналын хуудсыг хүчингүйд тооцно.

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын нэгдүгээр хавсралт



### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

|                                                                             |                                                                                                                                                                                 |
|-----------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Компанийн нэр:                                                              | “Инновэйшн инвестмент” Хувьцаат Компани                                                                                                                                         |
| Хаяг, утас:                                                                 | Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандигийн гудамж, НМ төв, 8 давхар , (+976) 7610-2211                                                                      |
| Хурал хуралдах өдөр, цаг:                                                   | 2026/05/18 15:00 цагт                                                                                                                                                           |
| Хурал хуралдах газар: /хаяг, байршил/                                       | <a href="https://agm.mn">https://agm.mn</a> холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр хуралдана                                                                                      |
| Хурлын төрөл:                                                               | Ээлжит бус                                                                                                                                                                      |
| Хурал зарлагч:                                                              | Саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан /Х.Доржсүрэн/                                                                |
| Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:                                      | Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн № 26/14 дугаар тогтоол                                                                                         |
| Олон нийтэд зарлах огноо:                                                   | 2026 оны 04 дүгээр сарын 13, 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр                                                                                                                |
| Бүртгэлийн өдөр:                                                            | 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр                                                                                                                                             |
| Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг Үнэт цаасны компанид хүргүүлэх огноо: | 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн дотор                                                                                                                                     |
| Хүргүүлсэн огноо:                                                           | 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр                                                                                                                                             |
| Хурлын даргын нэр:                                                          | А.Баттамир                                                                                                                                                                      |
| Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:                                    | Тооллогын комиссын дарга: “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Харилцагчийн албаны захирал Б.Онон<br>Тооллогын комиссын гишүүн: “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Харилцагчийн албаны мэргэжилтэн М.Оюунсүвд |
| Баримт, бичгийн жагсаалт /хавсралтаар/:                                     | Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоол, хавсралт<br>Хурлын зарын загвар                                                                                                             |
| Хурлын баримт бичгийн хуудсын тоо                                           | .....ширхэг<br>..... хуудас                                                                                                                                                     |

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

..... /Б.Энхболд/

2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр